



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Баян-Адарга

Г

Г

**Цэргийн бүртгэл явуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дүгээр зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2024 оны А/675 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|               |               |                                     |
|---------------|---------------|-------------------------------------|
| Дарга:        | Н.Ган-Адъяа   | (Засаг даргын Тамгын газрын дарга)  |
| Гишүүд:       | Б.Нямсүрэн    | (Дуурлиг багийн Засаг дарга)        |
|               | Г.Намсрай     | (Сайхан багийн Засаг дарга)         |
|               | Д.Баттогтох   | (Жаргалант багийн Засаг дарга)      |
|               | Г.Бишүүгармаа | (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн) |
| Нарийн бичиг: | Б.Төгсжаргал  | (Улсын бүртгэгч)                    |

2.2025 оны цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 26-ний өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

3.2024 оны жилийн эцсийн хүн амын статистик тоотой тулган, цэргийн тоо бүртгэлд хамрагдвал зохих хүмүүсийг бүрэн хамруулж, бүртгэлийг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, мэдээ судалгааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн хэлтэст хуваарийн дагуу хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Н.Ган-Адъяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ОЛХАГВАДОРЖ